



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.09 № 01/829
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-
ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ХАНДЫН ЭНХТҮВШИН ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Хандын Энхтүвшиний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хандын Энхтүвшиний Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Хандын Энхтүвшиний сонгуулийн мөрийн хөтөлбөр (2 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Хандын Энхтүвшинд

Хувийг: Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Сонгуулийн хороонд

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ХАНД ОВОГТОЙ ЭНХТҮВШИН
МИНИЙ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

НЭГ:Ерөнхий агуулга

Сум орон нутгийн онцлог, байгаль цаг уурын нөхцөл, хүн ардын аж амьдралын хэв маяг зэргийг харгалзан хүн ардад ээлтэй өрх гэр бүлийн хөгжлийг дэмжсэн өв соёлоо хадгалсан, хөдөө аж ахуйд тулгуурласан байгалийн нөөцөд түшиглэсэн, аялал жуулчлалыг дэмжсэн орон нутаг болно гэсэн эрхэм зорилгыг баримталж, иргэдийн аж байдал амьдрах орчныг сайжруулахад чиглэнэ.


ХОЁР: Хөтөлбөрийн үндсэн заалт

1. Өрхийн хөгжлийг дэмжих, орлого нэмэгдүүлэх чиглэлээр:

- ❖ Жижиг үйлдвэр үйлчилгээ, худалдаа эрхлэгчдийг дэмжих, төсөл хөтөлбөрт хамруулах бодлого барьж ажиллана.
- ❖ Цөөн малтай малчин өрхийг “ Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт”-т болон “Чинээлэг малчин” хөтөлбөрт хамруулахыг дэмжиж ажиллана.
- ❖ Өрхийн түвшинд хүнсний ногоо, хүлэмж, жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх нэр төрлийг олшруулах бодлого барьж ажиллана.
- ❖ Зөгийн аж ахуйг дэмжин, бүлийн тоог нэмэгдүүлэх, шинэ зоорь барих, зөгийчдийн холбоодтой холбох зэрэг ажлыг бодлогоор дэмжиж ажиллах
- ❖ Малчдын бүлэг, хуримтлалын бүлгийн ололт туршлагыг улам дэлгэрүүлж, иргэдээс гарсан үүсэл санаачилгыг дэмжинэ.
- ❖ “Чандмань” брэнд үзэсгэлэн худалдааг тогтмолжуулж, Мөрөн, Эрдэнэт, Улаанбаатар зэрэгт бүтээгдэхүүнийг борлуулах замаар орлогыг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана.
- ❖ Малчин өрхийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, орон сууц, хашаа хадлагийн талбайг хамгаалахад мод, модон материал олгогдох нөхцөлийг сайжруулах талаар эрх бүхий байгууллагад санал хүргүүлж, дэмжиж ажиллана.

2. Иргэд олон нийтэд

- ❖ Залуучууд хүүхдийн чөлөөт цагаа өнгөрөөх Чандмань цэцэрлэгт хүрээлэнг зураг төсвийн дагуу шийдвэрлэхийг дэмжинэ.
- ❖ Хүүхдийн тоглоомын талбай нэмж олшруулахыг дэмжиж ажиллана.
- ❖ Ахмадын шинэ байрны ашиглалтыг сайжруулан, ахмадын санаачлалыг дэмжин хамтран ажиллана
- ❖ Эмэгтэйчүүдийн байгууллага, эхчүүдийн алдрыг өргөх ажилд санаачилгатай дэмжиж ажиллана
- ❖ Хүүхэд залуу үеийн хүмүүжил төлөвшилд гэр бүлийн үүргийг нэмэгдүүлэн, харилцаа хандлагыг өөрчлөх олон арга хэмжээг санаачилна.
- ❖ “Эрүүл-Чандмань” хөтөлбөр боловсруулна.




Олуп

00000001

- ❖ Үндэсний болон орчин үеийн спортын ажлыг дэмжиж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах бодлого барьж ажиллана.
- ❖ Спортын бага олимп наадмыг 2 жил тутамд явуулахыг дэмжиж ажиллана.

3. Бусад асуудал

- ❖ Сумын 90-н жилд зориулан гаргасан номыг дахин шинэчлэх комисс байгуулж, орхигдсон зүйл алдааг засна.
- ❖ 2026 онд Их Монгол улс байгуулагдсан 820 жилд зориулан “Алунгоо эхийн сургаалын баяр-6” арга хэмжээг улам өргөжүүлэн агуулгыг баяжуулан зохион байгуулна.
- ❖ Аригийн голын нэгдсэн тахилгыг жил бүхэн Урианхайчуудын өв соёлын наадам болгон, аялал жуулчлалын шинэ эвент бий болгоно



МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН Х.ЭНХТҮВШИН

000000001